



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 05 өдөр

Дугаар A/666

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн "б", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Затус" ХХК-ний хийж гүйцэтгэсэн Жаргалант сумын Наран багийн жишиг гудамж байгуулах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Дөлбадрал -Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга

Гишүүд:

Б.Түмэндэмбэрэл -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

И.Цэрмаа -Жаргалант сумын Наран багийн Засаг дарга

Ц.Даваасамбуу -Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж -Аймгийн архивын тасгийн дарга

Д.Тэнгис - "Затус" ХХК-ний захирал

Нарийн бичгийн


дарга:

М. Д.Тогтохбаяр

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын Барилга хот байгуулалтын  
хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. “Затус” ХХК-ний хийж гүйцэтгэсэн ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн дотор багтаан захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН